



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



УЛСЫН ТӨСВИЙН 2024 ОНЫ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТ




НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААС




ТӨВ АЙМАГТ ЭРХ ШИЛЖҮҮЛСЭН

Улаанбаатар, 2024 оны 10 сарын 10




2024 онд хэрэгжиж дууссан төсөл арга хэмжээнд олгосон санхүүжилт

сая.төгрөг




- Гүйцэтгэгч
- Магадалшгүй ажлын зардал
- Захиалагчийн хяналтын зардал
- Зохиогчийн хяналтын зардал
- Зураг төсөв

Гэрээний хугацаа дуусаагүй төсөл, арга хэмжээ



- 2019-2022 онуудаас дамжин хэрэгжиж буй
- Тайлант оноос дамжин хэрэгжиж буй

Тайлант онд бүрэн хэрэгжсэн



Шинэ хөдөө төслөөр 90 иргэн, аж ахуйн нэгжид 578.0 сая төгрөгийн төмсний үрийг зээлээр, мөн 5 суманд 330.7 сая төгрөгийн хонь ноослогч төхөөрөмжийг олгожээ.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнээс Засгийн газрын тогтоол болон салбарын сайдын тушаалаар Төв аймгийн Засаг даргад 69,249.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 35,412.9 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 30 төсөл, арга хэмжээг эрх шилжүүлсэн байна.
- Тайлант онд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан 5 төсөл, арга хэмжээний үнэлгээний хороонд ажилласан зарим гишүүд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх зөрчил үүссэн тухай мэдэгдэлд гарын үсэг зураагүй байна.
- Зарим төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаа ТБОНӨХБАУХАТ хуулийн холбогдох заалтыг зөрчсөн байна.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжин он дамжин хэрэгжүүлж байсан 8 төсөл, арга хэмжээг бүрэн гүйцэтгэн ашиглалтад хүлээн авсан боловч, 3 төсөл арга хэмжээг бүрэн гүйцэтгэж дуусгахад шаардлагатай санхүүжилтийг дутуу баталснаас 3-5 жил дамжин хэрэгжүүлж байна.
- Зуунмод сумын Дулааны станцын халаалтын 1, 2, 3, 4, 5, 6, 7 дугаар хэсгийн 2 дугаар хэлхээний шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэл ажлын гэрээг цуцалсан байна. Өмнөх жилүүдэд дамжин хэрэгжиж, тайлант онд ашиглалтад хүлээн авсан зарим барилга, байгууламжийн ашиглалтад хүлээн авснаас хойш 7-10 сарын дотор эвдрэл, гэмтэл гарсан байна.
- Тайлант онд хүлээн авсан барилга байгууламжийн ажлуудын чанар, ашиглалтын байдлыг судлан тогтоож, илэрсэн зөрчил, доголдолыг чанарын баталгааны хугацаанд нь багтааж гүйцэтгэгч байгууллагаар арилгуулах арга хэмжээ авах шаардлагатай байна.
- Барилга байгууламж, их засварын ажилд тавих мэргэжлийн байгууллагын хяналт хангалтгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт, нотлох зүйлд үндэслэн

Аймгийн Засаг дарга Л.Төмөрчөдөр, Засаг даргын Тамгын газрын Бүс орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст зөвлөх нь:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжин 3-5 дахь жилдээ он дамжин хэрэгжиж буй 3 төсөл арга хэмжээг нэн тэргүүнд хэрэгжүүлэх талаар арга хэмжээг зохион байгуулах.
- Тайлант онд хүлээн авсан барилга байгууламжийн ажлуудын чанар, ашиглалтын байдлыг судлан тогтоож, илэрсэн зөрчил, доголдолыг чанарын баталгааны хугацаанд нь багтааж гүйцэтгэгч байгууллагаар арилгуулах.
- Барилга байгууламж, их засварын ажилд мэргэжлийн байгууллагаар нь буюу хяналтын төсөв хийсэн байгууллагатай нь зохиогчийн хяналтын гэрээг заавал байгуулж, хяналт тавиулах

Барилга, захиалагч орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ын дарга Ц.Дашдэмбэрэлд зөвлөх нь:

- Гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдтэй байгуулж буй ажил гүйцэтгэх гэрээнд тендерийн баримт бичигт заасан нөхцөлийг бүрэн тусгаж, гэрээг байгуулах,

Худалдан авах ажиллагааны газрын дарга С.Тамирт зөвлөх нь:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Сангийн сайдын 2023 оны А/254 дүгээр тушаалаар баталсан “Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдөж, ажиллах,